БАТЛАВ

ЗАХИРАЛ А. СЭНДМАА

# ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН 8-Р АНГИЙН НИЙГМИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа: 80 минут Хувилбар А Нийт оноо 100

1. Байнгын тогтвортой харилцааны үйлдлийн явцад нийтлэг адилсал, мэдрэмж бүхий болж бүрэлдэн тогтсон хоёр ба түүнээс дээш хүний нэгдлийг .................... гэнэ. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /2 оноо/

А. Гэр бүл Б. Хамт олон В. Нийгмийн бүлэг Г. Найз нөхөд

2. Зөрчилдөөнийг шалтгаанаас нь хамааруулан 3 ангилдаг. Илүүцийг олно уу? /2 оноо/

А. Материаллаг Б. Оюуны В. Нийгмийн Г. Аюулгүй байдлын

3.Өөрийн хүсэл эрмэлзэлээр үнэ хөлсгүйгээр орон нутаг, нийгмийнхээ төлөө хийж байгаа үйл ажиллагааг ...................... гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2 оноо/

А. Ажил хөдөлмөр Б. Олон нийтийн ажил В. Сайн дурын үйл ажиллагаа Г. Арга хэмжээ

4. Соёл нь биет болон биет бус хоёр хэлбэртэй. Биет соёлд хамаарахыг олоорой. /2 оноо/

А. Баяр наадам Б. Урлаг В. Домог үлгэр Г. Хөшөө дурсгал

5. Хүмүүсийн харилцаа, нийгмийн дэг журмыг зохицуулж байдаг зарчим шаардлагуудыг................ гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2 оноо/

А. Нийгэм Б. Нийгмийн харилцаа В. Хэм хэмжээ Г. Зөрчилдөөн

6. Худал хэлэхгүй байх, хулгай хийхгүй байх, үүрэг хариуцлагаа эрхэмлэдэг байх гэх мэт хүний зан араншин, авир үйлдлийг зохицуулдаг хэм хэмжээг ............... гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2 оноо /

А. Зан заншил Б. Ёс заншил В. Ёс суртахуун Г. Дэг журам

7. Дараах хэм хэмжээг зөв харгалзуулаарай. /6 оноо/

1. Зан заншил А. Худал хэлэхгүй байх, хулгай хийхгүй байх, үүрэг хариуцлагаа эрхэмлэдэг байх гэх мэт хүний зан араншин, авир үйлдлийг зохицуулдаг

2. Ёс суртахуун Б. Үндсэн хууль болон бусад дүрмүүд багтана.Энэ хэм хэмжээг зөрчвөл хуулийн хариуцлага хүлээнэ.

3. Албан хэм хэмжээ В. Буруу, зөв гэж хатуу үнэлэгддэггүй, тухайн ард түмний ёс заншил багтдаг.

8. Оюуны соёлын жишээг зөв илэрхийлсэн мөрийг олно уу./2 оноо/

| | | | | |
|---|---|---|---|---|
| А | Зан заншил | Сүхбаатарын талбай | Хөгжим | Мэдлэг |
| Б | Зүйр үгс | Жүжиг | Шинжлэх ухаан | Шашин |
| В | Ном | Машин техник | Уртын дуу | Гар утас |
| Г | Мэдлэг | Тоглоомын талбай | Уран зураг | Үлгэр домог |

9. Машин, тоног төхөөрөмж, барилга, зам гүүр, түүхий эд, материал, эд хогшил, мөнгө эдгээр нь аль үйлдвэрлэлийн нөөцөд хамаарах вэ? /2 оноо/

А. Газар Б. Ур чадвар В. Капитал Г. Хөдөлмөр

10. Аль тохиолдолд тэнцвэрт үнэ тогтох вэ? 2оноо

| | Эрэлтийн тоо хэмжээ | Нийлүүлэлтийн тоо хэмжээ | Илүүдэл/Хомсдол |
|---|---|---|---|
| А | 90000 | 60000 | -30000 |
| Б | 80000 | 80000 | = |
| В | 60000 | 100000 | +40000 |

11. Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ. Зөв хариулт аль нь вэ? /2 оноо/
А. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Үнэ
12. Тодорхой хэмжээний хөрөнгө оруулж, түүнийгээ арвижуулах үйл ажиллагааг ............... гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2 оноо/
А. Орон нутгийн төсөв Б. Зах зээл В. Үйлдвэрлэл Г. Бизнес
13. Үйлдвэрлэлийн нөөцөд хамаарахгүйг олоорой. /2 оноо/
А. Газар Б. Ур чадвар В. Хангамж Г. Капитал
14. Хүн бүр “хүн” болж төрснийхөө хувьд хамгийн эрхэм, үнэ цэнэтэй. Тиймээс ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран хүн бүрд хүндэтгэлтэй хандах ёстой. Хүний эрхийн ямар зарчим бэ? /2 оноо/
А. Салшгүй байх зарчим Б. Түгээмэл байх зарчим В. Хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчим Г. Хуваагдашгүй байх зарчим
15. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвөл сэргээн эдлүүлэх нь төрийн ямар үүрэг вэ? /2 оноо/
А. Хангах Б. Хүндэтгэх В. Хамгаалах Г. Ахиц дэвшил гаргах
16. Хүмүүс хоорондын тэгш бус харилцаа үүсэх анхдагч нөхцөл болдог ялгарлыг олоорой. (Хүний нас, хүйс, үндэс угсаа, биеийн хүч зэрэг нь энэ ялгаралд хамаардаг. ) /2 оноо/
А. Төрөлхийн Б. Төрөлхийн бус
17. Харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төлөөлөгчийг олно уу. /2 оноо/
А. ИНТ Б. ИНХ В. Засаг дарга Г. Орон нутгийн зөвлөл
18. Гарч буй бодлого, шийдвэрийн агуулга, цар хүрээ, найруулга зэргийг мэргэжлийн ажилтнууд эсвэл, хурлын төлөөлөгчид, Засаг даргын ажлын алба боловсруулдаг. Энэ нь орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын ямар үе шат вэ? /2 оноо/
А. Үнэлгээ хийх Б. Хэлэлцэх В. Санаачлах Г. Боловсруулах
19. Дараах эдийн засгийн ойлголтуудыг зөв харгалзуулаарай. /6 оноо/

| | |
|---|---|
| 1. Эрэлт | А. Худалдан авагчийн хүсэл монирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авах боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ. |
| 2. Нийлүүлэлт | Б. Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ. |
| 3. Үнэ | В. Эрэлт нийлүүлэлтийн муруйн огтлолцлын цэгийг хэлнэ. |
| 4. Тэнцвэрт үнэ | Г. Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа төлж буй мөнгөн дүн. |

20. Зөв харгалзуулаарай. /6 оноо/

| | |
|---|---|
| 1. Төрийн байгууллага | А. Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг ашиг олох зорилготой байгууллага |
| 2. Төрийн бус байгууллага | Б. Төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байдаг, төсвөөс санхүүждэг байгууллага |
| 3. Аж ахуйн нэгж | В. Өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр нэгдэн үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө бус байгууллага |

21. Зөрчилдөөнийг шийдвэрлэх олон янзын хандлага бий. Тэдгээрийн нэг болох Томас Киллманы зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагад хамааралгүйг олно уу. /2 оноо/
А. Зайлсхийх Б. Буулт хийх В. Хамтран ажиллах Г. Асуудлаас бултах
22. Зөрчилдөөнийг цар хүрээгээр нь хэрхэн ангилдаг вэ? /2 оноо/

А. Ил болон далд Б. Ширүүн болон алгуур В. Богино болон урт Г . Макро болон микро

23. Хувь хүний соёлын бүтцийн орхигдсон ойлголтыг зөв дугуйлаарай. /2 оноо/




А. Яриа Б. Бичиг В. Үсэг Г .Бэлгэдэл

24. Мөнгөтэй түүнийгээ зарцуулах сонирхолтой худалдан авагчид буюу хэрэглэгчид, тэдэнд бараагаа борлуулж ашиг олох сонирхолтой худалдагчид буюу үйлдвэрлэгчдийн хоорондын харилцан үйлчлэлийг ................... гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2 оноо/

А. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Тэнцвэрт үнэ

25. Эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр зах зээлд ............... тогтоно. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2оноо/

А. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Тэнцвэрт үнэ

26. Хүмүүс нас, хүйс, арьс үндэс, нийгмийн анги давхраа зэргээс үл хамааран хүн болон мэндэлснийхээ хувьд эрх тэгш байна. Хүн бүрийн эрхэм зэргийг хүндэтгэн, аливаа байдлаар алагчлах, ялгаварлан гадуурхах ёсгүй. Хүний эрхийн ямар зарчим бэ? /2 оноо/

А. Түгээмэл байх зарчим Б. Тэгш байх зарчим В. Харилцан хамааралтай байх зарчим Г. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим

27. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвөл сэргээн эдлүүлэх нь төрийн хүлээх аль үүрэг вэ? /2 оноо/

А. Хангах Б. Хүндэтгэх В. Хамгаалах Г. Ахиц дэвшил гаргах

28. Орон нутгийн удирдлагаас гарах бодлого, шийдвэрийг ИНХ, ИТХ-ын тэргүүлэгчид тогтоол гарган, бүх шатны Засаг дарга нар захирамж, тушаал гарган батлах нь орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын ямар үе шат вэ? /2оноо/

А. Үнэлгээ хийх Б. Хэлэлцэх В. Санаачлах Г. Батлах

29 . Дараах ойлголтуудыг зөв харгалзуулаарай. /6 оноо/

1. Иргэн А. Тухайн улсын хуулиар иргэддээ тогтоож өгсөн эрх, эрх чөлөө
2. Иргэний эрх Б. Тухайн улс орны хууль ёсны харьяалал бүхий хүн
3. Иргэний үүрэг В. Тухайн улсын хуулийн дагуу иргэдийн биелүүлбэл зохих шаардлагууд

30. Аль нь зөв зураглал вэ? /2оноо/



31. Хүний эрх нь төрөөс олгож буй “хишиг” биш, харин хүн төрж мэндлэхэд нь хамт заяадаг түүний төрөлх чанар юм. Иймд хүний эрх нь хүн бүрийн амьдралын салшгүй хэсэг байна. Хүний эрхийн ямар зарчим бэ? /2 оноо/

А. Хуваагдашгүй байх зарчим Б. Салшгүй байх зарчим В. Тэгш байх зарчим Г. Хариуцлага хүлээх зарчим

32. Иргэд өөрийн орон нутгийн баг хорооны ИНХ-д шууд оролцож, ИТХ-ын төлөөлөгчдийг шууд сонгодог. /2 оноо/

А. Тийм Б. Үгүй

33. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүргүүдийг зөв харгалзуулаарай. /6 оноо/

| | |
|---|---|
| 1. Хамгаалах | А. Төр хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулна. |
| 2. Хангах | Б. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвөл сэргээн эдлүүлэх |
| 3. Хүндэтгэх | В. Төрийн зүгээс сургууль, эмнэлгийг байгуулах зэргээр хүн бүр эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ. |
| 4. Ахиц дэвшил гаргах | Г. Хүний эрхийн талаарх ололт амжилтаа бататгаж ямагт ахиц дэвшил гаргах |

34. Байнгын тогтвортой харилцааны үйлдлийн явцад нийтлэг адилсал, мэдрэмж бүхий болж бүрэлдэн тогтсон хоёр ба түүнээс дээш хүний нэгдлийг .................... гэнэ. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /2 оноо/

35. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зөв харгалзуулна уу. /2 оноо/

1. Үйлчилгээ А. Төрөл бүрийн бараа худалдан авч, хадгалах, тээвэрлэх, худалдах үйл явц

2. Үйлдвэрлэл Б. Хүмүүсийн хэрэгцээг хангах зорилготой бодит бус шинжтэй үйл ажиллагаа явуулах

3. Худалдаа В. Хэрэглэгчдийн хэрэгцээ хангах чадвартай материаллаг биет зүйлс үйлдвэрлэн гаргах

А. 1а 2в 3б Б. 1в 2а 3б В. 1б 2в 3а Г. 1а 2б 3в

36. 1. Эрх эдлэгч А. Бусдын эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ.

2. Үүрэг хүлээгч Б. Хүний эрх зөрчигчдөд хариуцлага оногдуулна. /2оноо/

А. 1А 2Б Б. 1Б 2А

37. орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явц хэдэн үе шаттай вэ?/2 оноо/

А. 4 Б. 5 В. 6 Г. 7

38. Монгол улсын засаг захиргааны нэгжийг зөв харгалзуулаарай. /6 оноо/

| | |
|---|---|
| 1. Аймаг, нийслэл | А. ИНХ |
| 2. Сум, дүүрэг | Б. Сум дүүргийн засаг дарга |
| 3. Баг, хороо | В. ИТХ |

39. Эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх нь аль нь вэ? /2 оноо/

А. Баг хорооны ИНХ Б. Сум дүүргийн ИТХ В. Аймгийн засаг дарга

40. Орон нутгийн шийдвэр гаргах үйл явцаас аль нь илүүц вэ? /2 оноо/

А. Санаачлах Б. Боловсруулах В. Хэлэлцэх Г. Дүгнэх

| А Хувилбар |
| --- |
| 1Г |
| 2А |
| 3В |
| 4В |
| 5А |
| 6Г |
| 7Б |
| 8А |
| 9В |
| 10Б |
| 11В |
| 12Б |
| 13Г |
| 14Б |
| 15В |
| 16Б |
| 17Б |
| 18А |
| 19. 1А 2Б 3Г 4В |
| 20. 1А 2В 3Б |
| 21Г |
| 22Г |
| 23Г |
| 24В |
| 25Г |
| 26Г |
| 27В |
| 28Г |
| 29. 1Б 2А 3В |
| 30Б |
| 31Б |
| 32А |
| 33. 1Б 2В 3А 4Г |
| 34А |
| 35А |
| 36Б |
| 37В |
| 38. 1В 2Б 3А |
| 39А |
| 40Г |

БАТЛАВ

ЗАХИРАЛ А. СЭНДМАА

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН 8-Р АНГИЙН НИЙГМИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа: 80 минут Хувилбар Б Нийт оноо 100

1. ........................ гэдэг нь хүмүүсийн хамтын амьдрал, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр, өөр хоорондоо харилцан үйлчлэлцэж буй хувь хүмүүс, бүлэг, байгууллагууд, тэдгээрийн хоорондын харилцааны цогц юм. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2 оноо/

А. Нийгэм Б. Нийгмийн харилцаа В. Нийгмийн орчин Г. Нийгмийн үйлдэл

2. Соёл нь биет болон биет бус хоёр хэлбэртэй. Биет бус соёлд хамаарахыг олоорой./2 оноо/

А. Археологийн олдвор Б. Барилга байгууламж В. Зан заншил Г. Хөшөө дурсгал

3. Материаллаг соёл аль нь вэ? /2 оноо/

А. Археологийн олдвор Б. Уртын дуу В. Баяр наадам Г. Дээрх бүгд

4. Оюуны соёлын жишээг зөв илэрхийлсэн мөрийг олно уу. /2оноо/

| | | | | |
|---|---|---|---|---|
| А | Урлаг | Машин техник | Хөгжим | Боловсрол |
| Б | Боловсрол | Жүжиг | Урлаг | Шашин |
| В | Уртын дуу | Барилга | Археологийн олдвор | Хөгжим |
| Г | Мэдлэг | Тоглоомын талбай | Уран зураг | Үлгэр домог |

5. Үйлдвэрлэлийн нөөцөд хамаарахыг олоорой. /2 оноо/

А. Хөдөлмөр Б. Хэрэгцээ В. Үйлчилгээ Г. Худалдаа

6. Эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр зах зээлд ................ тогтоно. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2 оноо/

А. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Тэнцвэрт үнэ

7. Орон нутгийн эдийн засгийн салбаруудад үл хамаарахыг олоорой./2 оноо/

А. Үйлдвэрлэл Б. Худалдаа, үйлчилгээ В. Хөдөө аж ахуй Г. Соёлын төв

8. Орон нутгийн түвшинд бодлого шийдвэр аль түвшинд гарахаас хамаарч хурлын төлөөлөгч, намын бүлэг, засаг дарга, түүний ажлын алба санаачилдаг энэ нь орон нутгийн бодлого, шийдвэр гаргах үйл явцын аль үе шат вэ? /2 оноо/

А. Санаачлах Б. Хэлэлцэх В. Хэрэгжүүлэх Г. Үнэлэх

9. Бүх нийтээр даган мөрдөхөөр төрөөс тогтоосон хэм хэмжээний тогтолцоог ................... гэнэ. /2 оноо/

А. Эрх зүй Б. Ёс зүй В. Зан заншил Г. Итгэл үнэмшил

10. 13 настай “Д” гэр бүлээ тэжээхийн тулд сургуулиас гарч Нарантуул зах дээр тэрэг түрдэг гэвэл түүний ямар эрх зөрчигдөж байна вэ? /2 оноо/

А. Сурч боловсрох эрх Б. Хөдөлмөрлөх эрх В. Аюулгүй байх эрх Г. Үзэл бодлоо илэрхийлэх эрх

11. Нэгэн хорооны нутаг дэвсгэрт нийтэд зориулсан хогийн сав хангалтгүй учир орчны бохирдол улам бүр нэмэгдсээр байна. Энэ нь иргэдийн ямар эрх зөрчигдөж байна вэ? /2 оноо/

А. Амьд явах эрх Б. Халдашгүй байх эрх В. Эрүүл байх эрх Г. Эвлэлдэн нэгдэх эрх

12. Зөрчилдөөний гадуур үлдэх, хэлэлцэн зөвшилцөхийг үл ойшоох, эсвэл төвийг сахисан байр суурь баримтлах нь зөрчилдөөнийг шийдвэрлэх аль хандлагад хамаарах вэ? /2 оноо/

А. Сөргөлдөх Б. Зайлсхийх В. Буулт хийх Г. Хамтран ажиллах

13. Бодитой, тодорхой, нягтлан шалгаж болохуйц мэдээллийг .......................... гэнэ. /2 оноо/
А. Таамаглал Б. Баримт В. Санаа бодол Г. Үзэл санаа
14. Үйлдвэрлэлийн нөөцийг зөв харгалзуулаарай. /6оноо/

| | |
|---|---|
| 1. Газар | А. Хүний оюуны ба биеийн хүчний чадавх |
| 2. Капитал | Б. Газрын хэвлий дэх бүх баялаг |
| 3. Хөдөлмөр | В. Машин тоног төхөөрөмж, түүхий эд |

15. Хэм хэмжээг хэрхэн ангилдаг вэ? /2 оноо/
А. Биет ба биет бус Б. Албан ба албан бус В. Материаллаг ба оюуны Г. Ил ба далд
16. Иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрх нэгдмэл, хуваагдашгүй байна. Хүн бүр олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх, эрх чөлөөг бүрэн эдлэх ёстой. . Хүний эрхийн ямар зарчим бэ?/ 2 оноо/
А. Хуваагдашгүй байх зарчим Б. Тэгш байх зарчим В. Хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчим Г. Салшгүй байх зарчим
17. Гарч буй бодлого, шийдвэрийн агуулга, цар хүрээ, найруулга зэргийг мэргэжлийн ажилтнууд эсвэл, хурлын төлөөлөгчид, Засаг даргын ажлын алба боловсруулдаг. Энэ нь орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын ямар үе шат вэ? /2 оноо/
А. Үнэлгээ хийх Б. Хэлэлцэх В. Санаачлах Г. Боловсруулах
18. Анхдагч бүлэг аль нь вэ? /2 оноо/
А. Найз нөхөд Б. Сургууль В. Дугуйлан Г. Эмнэлэг
19. Гэрлэлт болон цусан төрлийн холбоогоор холбогдсон, нэгдмэл амьдрал бүхий хүмүүсийн нэгдлийг аль нь зөв илэрхийлж байна вэ? /2 оноо/
А. Гэр бүл Б. Хамаатан садан В. Нийгмийн бүлэг Г Хамт олон
20. Соёлын өөрчлөлтөд нөлөөлөхгүй хүчин зүйлийг олоорой./2оноо/
А. Байгаль орчин Б. Нээлт, бүтээл В. Соёлуудын харилцан нөлөөлөл, нэвчилт Г. Нийгмийн харилцаа
21. Ямар нэгэн үр ашигтай, үр дүнд чиглэсэн, хүний биеийн болон оюуны үйл ажиллагааг ......................гэнэ./2оноо/
А. Хөдөлмөр Б. Мөнгө В. Капитал Г. Газар
22. Үйлдвэрлэлийн нөөцийг дурдахдаа хамраалгүй зүйл оруулсан бол аль нь вэ?/ 2 оноо/
А. Төр Б. Хөдөлмөр В. Ур чадвар Г Газар

23. Хүний эрхийн зарчмуудыг зөв харгалзуулаарай. /6 оноо/

| | |
|---|---|
| 1. Ялгаварлан гадуурхахгүй байх | А. Хүний бүх эрх, эрх чөлөө адил тэгш байх |
| 2. Хуваагдашгүй байх | Б. Иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын зэрэг хүний эрх нэгдмэл хуваагдашгүй байна. |
| 3. Тэгш байх | В. Нас, хүйс, арьс үндэс, нийгмийн анги давхаргаас үл хамааран эрх тэгш байна. |

24. Хүний нэг эрх зөрчигдөхөд бусад эрх мөн зөрчигдөх үндэс болно. Иймд хүний эрхийн бүхий л асуудлыг өөр хоорондоо нь харилцан хамааралтай, цогц байдлаар шийдвэрлэх ёстой. Хүний эрхийн ямар зарчим бэ? /2 оноо/
А. Харилцан хамааралтай байх зарчим Б. Салшгүй байх зарчим В. Хариуцлага хүлээх зарчим зарчим Г. Тэгш байх зарчим
25. Зөв харгалзуулаарай. /6 оноо/

1. Таамаглал А. Бодитой, тодорхой, нягтлан шалгаж болохуйц мэдээлэл байна.
2. Санаа бодол Б. Аливаа зүйлийн талаарх итгэл үнэмшил, төсөөлөл байна.
3. Баримт В. Асуудлын учир шалтгааныг өөрт байгаа мэдээлэл, мэдлэг, туршлагад тулгуурлан дэвшүүлсэн илэрхийлэл.

26. Худал хэлэхгүй байх, хулгай хийхгүй байх, үүрэг хариуцлагаа эрхэмлэдэг байх гэх мэт хүний зан араншин, авир үйлдлийг зохицуулдаг хэм хэмжээг ............... гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2оноо/

А. Зан заншил Б. Ёс заншил В. Ёс суртахуун Г. Дэг журам

27. Хүн бүр бусдын эрхийг хүндэтгэх, хангах, эрхээ шаардах, мөн хүний эрхийн зөрчилтэй тэмцэх үүрэгтэй. Мөн төр, төрийн ба бизнесийн байгууллага зэрэг нийгмийн бусад нэгж хэсгүүд хүний эрхийг хангах, хөхиүлэн дэмжих, хамгаалах үүрэг хүлээдэг. /2оноо/

А. Харилцан хамааралтай байх зарчим Б. Салшгүй байх зарчим В. Хариуцлага хүлээх зарчим зарчим Г. Тэгш байх зарчим

28. Тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцох байдал, идэвхийг хэрхэн нэрлэдэг вэ? /2 оноо/

А. Мэдээлэл Б. Оролцоо В. Шийдвэр Г. Бодлого

29. Хүний бүх эрх, эрх чөлөө адил тэгш хүчинтэй байх бөгөөд нэг эрх нь бусдаас илүү чухал, давуу гэж үзэж болохгүй. /2оноо/

А. Харилцан хамааралтай байх зарчим Б. Салшгүй байх зарчим В. Хариуцлага хүлээх зарчим зарчим Г. Тэгш байх зарчим

30. Зөв харгалзуулаарай. /6 оноо/

| | |
|---|---|
| 1. Оюуны соёл | А. Хууль дүрэм |
| 2. Материаллаг соёл | Б. Шашин, домог |
| 3. Албан хэм хэмжээ | В. Ёс заншил |
| 4. Албан бус хэм хэмжээ | Г. Хөшөө дурсгал |

31. Хэм хэмжээ/а/, соёл /б/ гэсэн ойлголтуудын хамаарлыг аль бүдүүвчээр илэрхийлж болох вэ? /2 оноо/

А. Б. В.




32. Хүн бүр “хүн” болж төрснийхөө хувьд хамгийн эрхэм, үнэ цэнэтэй. Тиймээс ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран хүн бүрд хүндэтгэлтэй хандах ёстой. Хүний эрхийн ямар зарчим бэ? /2 оноо/

А. Салшгүй байх зарчим Б. Түгээмэл байх зарчим В. Хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчим Г. Хуваагдашгүй байх зарчим

33. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвөл сэргээн эдлүүлэх нь төрийн ямар үүрэг вэ? /2 оноо/

А. Хангах Б. Хүндэтгэх В. Хамгаалах Г. Ахиц дэвшил гаргах

34. Хүмүүс хоорондын тэгш бус харилцаа үүсэх анхдагч нөхцөл болдог ялгарлыг олоорой. (Хүний нас, хүйс, үндэс угсаа, биеийн хүч зэрэг нь энэ ялгаралд хамаардаг. ) /2 оноо/

А. Төрөлхийн Б. Төрөлхийн бус

35. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүргүүдийг зөв харгалзуулаарай. /6 оноо/

| | |
|---|---|
| 1. Хамгаалах | А. Төр хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулна. |
| 2. Хангах | Б. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвөл сэргээн эдлүүлэх |
| 3. Хүндэтгэх | В. Төрийн зүгээс сургууль, эмнэлэгийг байгуулах зэргээр хүн бүр эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ. |
| 4. Ахиц дэвшил гаргах | Г. Хүний эрхийн талаарх ололт амжилтаа бататгаж ямагт ахиц дэвшил гаргах |

36. Харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төлөөлөгчийг олно уу. /2 оноо/

А. ИНТ Б. ИНХ В. Засаг дарга Г. Орон нутгийн зөвлөл

37. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвөл сэргээн эдлүүлэх нь төрийн хүлээх аль үүрэг вэ? /2 оноо/

А. Хангах Б. Хүндэтгэх В. Хамгаалах Г. Ахиц дэвшил гаргах

38. Орон нутгийн удирдлагаас гарах бодлого, шийдвэрийг ИНХ, ИТХ-ын тэргүүлэгчид тогтоол гарган, бүх шатны Засаг дарга нар захирамж, тушаал гарган батлах нь орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын ямар үе шат вэ? /2оноо/

А. Үнэлгээ хийх Б. Хэлэлцэх В. Санаачлах Г. Батлах

39. Мөнгөтэй түүнийгээ зарцуулах сонирхолтой худалдан авагчид буюу хэрэглэгчид, тэдэнд бараагаа борлуулж ашиг олох сонирхолтой худалдагчид буюу үйлдвэрлэгчдийн хоорондын харилцан үйлчлэлийг .................... гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2 оноо/

А. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Тэнцвэрт үнэ

40. Эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр зах зээлд ................ тогтоно. Цэгийн оронд тохирохыг олно уу. /2оноо /

А. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Тэнцвэрт үнэ

| Б Хувилбар |
| --- |
| 1А |
| 2В |
| 3А |
| 4Б |
| 5А |
| 6Г |
| 7Г |
| 8Г |
| 9А |
| 10А |
| 11В |
| 12Б |
| 13Б |
| 14. 1Б 2В 3А |
| 15Б |
| 16А |
| 17Г |
| 18А |
| 19А |
| 20Г |
| 21А |
| 22А |
| 23. 1В 2Б 3А |
| 24А |
| 25. 1В 2Б 3А |
| 26В |
| 27В |
| 28Б |
| 29Г |
| 30. 1Б 2Г 3А 4Б |
| 31А |
| 32В |
| 33В |
| 34А |
| 35. 1Б 2В 3А 4Г |
| 36В |
| 37В |
| 38Г |
| 39Б |
| 40Г |